

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/01/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn
Эрдэнэт хот

2023 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: В.Жавзмаа
Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.04.24 № 103
танай _____-ны № _____-г

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА С.БАТЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгай шилжүүлгийн байгууллага болох боловсрол, соёл, газрын харилцаа, хүүхэд хамгаалал, эрүүл мэндийн байгууллагууд харьяа төсвийн төвлөрүүлэн захирагчид нэгтгэгдэх болсонтой холбоотой 152,959.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 4,499.2 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн байна.

Азийн хөгжлийн банк, Монгол Улсын Засгийн газар хоорондын МОН 2301 төслийн зээлийн үлдэгдэл 7,446.7 сая төгрөгийг улсын төсөвт суутгуулж, өр төлбөр буурсан байна.

Сангийн яам Өрийн удирдлагын тухай хуулийн дагуу гадаадын зээлийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн "Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл" төслийн зээл 13,621.4 сая төгрөгийг суутган тооцсоныг улсын комисс хүлээж аваагүй, өмчлөгчийн асуудал шийдвэрлэгдээгүй тул "урьдчилж гарсан зардал"-аар тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын төсөл хөтөлбөр, Эрдэнэт сангийн зардлаас орон нутгийн өмчийн болон хувийн хэвшлийн байгууллагын үйл ажиллагааны санхүүжилтэд 2,498.0 сая төгрөгийг зарцуулж байгаа нь төсвийг үр ашигтай удирдаж, санхүүгийн сахилга батыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлаагүйтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Орхон аймгийн Засаг даргын Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилтийг 2022 онд 88.4 хувьтай биелүүлж ажилласан байна.

Орхон аймгийн Засаг даргын 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтэд тусгасан 8 бүлэг, 18 дэд бүлэг, 124 зорилтын хүрээнд 251 арга хэмжээг 88.4 хувьтай хэрэгжүүлж, 1 арга хэмжээ 2023 оноос хэрэгжихээр хүлээгдэж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	60,156,921.8	83,268,157.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	33,196,658.3	43,516,009.1
33	АВЛАГА	19,515,179.7	20,091,134.7
34	УРЬДЧИЛГАА	0.0	13,621,448.8
35	БАРАА МАТЕРИАЛ	7,415,083.8	5,949,684.6
36	НӨӨЦИЙН БАРАА	30,000.0	89,880.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	321,438,913.8	234,736,895.7
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	100,000.0	100,000.0
37200	Үнэт цаас	100,000.0	100,000.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	321,338,913.8	234,636,895.7
39200	Биет хөрөнгө	295,410,610.7	224,666,068.2
39300	Биет бус хөрөнгө	25,928,303.0	9,970,827.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	381,595,835.6	318,005,052.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	37,353,114.2	31,511,226.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	24,839,354.0	25,146,856.3
41300	Өглөг	22,566,577.6	22,947,902.2
41400	Урьдчилж орсон орлого	2,272,776.4	2,198,954.1
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,513,760.2	6,364,370.5
42200	Урт хугацаат зээл	12,513,760.2	6,364,370.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	344,242,721.4	286,493,826.2
51	Засгийн газрын хувь оролцоо	344,242,721.4	286,493,826.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	66,865,003.1	17,176,568.0
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	16,145,725.1	23,068,468.6
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	43,306,708.4	58,737,174.8
51200	Хуримтлагдсан үр дүн	136,920,465.6	172,270,033.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	81,004,819.2	15,241,581.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	381,595,835.6	318,005,052.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	187,835,073.9	251,016,915.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	78,263,858.3	197,206,303.0
110	Орлогын албан татвар	42,252,992.2	147,234,680.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	44,663,814.3	56,900,096.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-2,410,822.2	-3,802,030.5
1103	ААН-ийн орлогын албан татвар	0.0	94,136,614.5
113	Хөрөнгийн албан татвар	13,038,898.3	23,729,027.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	22,971,967.8	26,242,594.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	96,104,032.5	33,352,234.9
120	Нийтлэг татварын бус орлого	47,729,454.2	23,457,171.7
122	Тусламжийн орлого	839,933.0	58,811.9
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	47,534,645.4	9,836,251.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,467,183.1	20,458,377.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	124,874,417.3	157,716,113.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	124,874,417.3	157,716,113.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	96,744,066.9	63,898,848.5

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,560,897.6	9,947,511.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,524,757.0	1,288,513.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,601,701.6	3,604,324.2
2104	Хангамж, бараа материалын зардал	3,262,418.3	3,885,979.7
2105	Нормативт зардал	1,051,335.5	148,347.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,919,135.6	1,401,952.0
2107	Томилолт, зочны зардал	150,523.4	74,225.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,293,707.8	25,202,968.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,379,590.3	18,345,026.1
212	ТАТААС	1,030,857.6	1,182,752.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,099,492.8	92,634,512.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	62,960,656.6	93,300,802.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	456,181.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	20,926,258.3	174,943,471.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	42,034,398.4	-81,186,487.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	299,844,034.9	299,844,034.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,035,601.2	1,035,601.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	300,879,636.1	300,879,636.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-579,776.9	-579,776.9
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	841,498.4	841,498.4
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
Өмчид гарсан өөрчлөлт	1,066,965.4	1,066,965.4
Зарласан ногдол ашиг	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	42,034,398.4	42,034,398.4
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	344,242,721.4	344,242,721.4
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	344,242,721.4	344,242,721.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	49,553.4	49,553.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	344,292,274.8	344,292,274.8
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-35,851.2	-35,851.2
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	36,120.0	36,120.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
Өмчид гарсан өөрчлөлт	23,387,769.9	23,387,769.9
Зарласан ногдол ашиг	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	-81,186,487.4	-81,186,487.4
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	286,493,826.2	286,493,826.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	173,655,407.0	249,654,887.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	78,263,858.3	174,943,408.7
110	Орлогын албан татвар	42,252,992.2	124,971,786.4

1100	Хувь хүний орлогын албан татвар	44,663,814.3	56,900,096.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-2,410,822.2	-3,802,030.5
1103	ААН-ын орлогын албан татвар	0.0	71,873,720.2
113	Хөрөнгийн албан татвар	13,038,898.3	23,729,027.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	22,971,967.8	26,242,594.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,108,365.8	2,677,646.0
1181	Газрын төлбөр	19,483,775.1	23,216,125.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	379,827.0	348,823.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	80,514,098.6	52,639,915.3
120	Нийтлэг татварын бус орлого	32,979,453.2	42,803,664.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	47,534,645.4	9,836,251.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,877,450.1	22,071,563.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	133,690,945.8	173,815,843.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	133,690,945.8	173,815,843.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	105,477,848.8	78,333,926.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,304,453.6	14,671,277.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,572,565.2	2,652,385.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,027,988.7	4,278,723.2
2104	Хангамж, бараа материалын зардал	3,574,700.7	4,435,373.5
2105	Нормативт зардал	961,605.4	193,849.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,022,100.9	1,442,587.6
2107	Томилолт, зочны зардал	148,949.2	74,225.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,249,663.0	38,361,100.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,615,822.1	12,224,403.2
212	ТАТААС	1,030,857.6	1,182,752.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,182,239.4	94,299,165.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	39,964,461.2	75,839,043.7
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	12,500.0	20,674.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	39,352,472.0	65,403,713.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	39,352,472.0	65,403,713.7
2200	Дотоод эх үүсвэрээр	39,352,472.0	65,403,713.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-39,339,972.0	-65,383,039.3
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-153,301.7	-136,653.6
14	Бусад эх үүсвэр	501,408.7	475,446.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	401,590.0	383,100.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	253,120.4	229,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	471,187.5	10,319,350.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	32,725,470.8	33,196,658.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	33,196,658.3	43,516,009.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	206,263,843.8	184,587,669.8
УРСГАЛ ЗАРДАЛ	143,697,200.5	131,332,686.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	49,904,219.7	37,633,929.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,269,863.5	9,486,954.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,383,555.3	1,212,712.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,954,810.9	3,429,258.9
Хангамж, бараа материалын зардал	1,960,178.7	1,940,611.8
Нормативт зардал	129,977.5	119,033.6
Эд хогшил, урсгал засварын зардал	1,292,686.9	1,287,829.4
Томилолт, зочны зардал	67,245.1	62,576.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,123,457.0	18,454,967.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,722,444.8	1,639,985.2
ТАТААС	1,200,000.0	1,182,752.2
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,200,000.0	1,182,752.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,592,980.8	92,516,004.3
Засгийн газрын урсгал шилжүүлэг	91,808,947.2	91,803,424.5
Бусад урсгал шилжүүлэг	784,033.6	712,579.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	62,008,460.5	52,871,883.6
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	558,182.8	383,100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	206,263,843.8	185,426,779.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,915,501.9	9,836,251.3
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	160,701,022.5	168,191,157.1
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	35,647,319.4	7,399,370.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	4,576,906.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	5,415,818.6

Гурав. Аудитын илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 1 төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд аудит хийж, “өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 19.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын хугацаанд залруулга хийгээгүй бөгөөд 19.8 сая сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн.

2. Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар: Нийт 33 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийж, 17 байгууллагын санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийж, 16 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж ажиллалаа.

Нягтлан бодох бүртгэл, тайлагнал, хууль журмын хэрэгжилттэй холбоотой 1,966.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 18.7 сая төгрөгийн алдааг залруулж, 64.6 сая төгрөгийн зөрчилд 43 төлбөрийн акт тогтоож, 1,692.4 сая төгрөгийн зөрчилд 29 албан шаардлага, 222.2 сая төгрөгийн зөрчилд 67 зөвлөмж хүргүүлсэн. Үүнээс 1 зөрчил Шилэн данс хуулийн хэрэгжилттэй, 71.1 сая төгрөгийн зөрчил Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой байна.

3. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдийн санхүүгийн тайлангийн аудитын талаар: Нийт 7 орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийж, 1 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийж, 6 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж ажилласан байна.

Нягтлан бодох бүртгэл, тайлагнал, хууль журмын хэрэгжилттэй холбоотой 603.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын хугацаанд 61.2 сая төгрөгийн 8 алдааг залруулж, 12.8 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоож, 416.0 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, 113.1 сая төгрөгийн зөрчилд 20 зөвлөмж хүргүүлсэн. Үүнээс 2 зөрчил Шилэн данс хуулийн хэрэгжилттэй, 18.6 сая төгрөгийн зөрчил Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2022 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар “өөрчлөлтгүй” санал дүгнэлт 1, “хязгаарлалттай” санал дүгнэлт 4, “сөрөг” санал дүгнэлт 1-ийг гаргаж, байгууллагын удирдлага бүрд албан бичгээр хүргүүлсэн.

Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитаар нийт 7.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 7.5 сая төгрөгийн алдааг залрууллаа. Төрийн аудитын байгууллагын аудит хийж баталгаажуулсан тайлангаас 7.5 сая төгрөгийн зөрүүтэй буюу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцааны дансны үлдэгдэл 4.8 сая төгрөг, дансны авлага /ТӨҮГ/ 11.9 сая төгрөг, богино хугацаат өр төлбөр дансыг 9.5 сая төгрөгөөр дутуу, үндсэн хөрөнгө дансанд 24.2 сая төгрөг, Засгийн газрын хувь оролцоо дансыг 17.0 сая төгрөгөөр илүү нэгтгүүлснийг залруулсан.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 3,105.8 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 2,498.0 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 607.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Эрдэнэт сангийн авлагыг Орхон аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дансанд төвлөрүүлснийг Орхон аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын өр төлбөрт суутган шилжүүлж, одоог болтол гэм буруутай этгээдээр төлүүлээгүйгээс авлагын данс үлдэгдэлтэй байгаа болон иргэнээс авах авлагыг барагдуулаагүй, иргэн төлөх график гаргасан боловч төлөхгүй байгаад хяналт хэрэгжүүлээгүй зэрэг асуудлыг шийдвэрлүүлэхээр хуулийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн хэдий хуулийн байгууллага хянаж буй тул зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогүй болно.

5.2 Албан шаардлага

Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр зарцуулдаг Засаг даргын төсөл хөтөлбөрийн зардлаас 25 төрийн болон төрийн бус байгууллагын 200 гаруй ажилтны цалингийн санхүүжилтэд 2,498.0 сая төгрөгийг олгосон, тэмдэглэлт баяр ёслол, хүлээн авалтын хоол, сургалтын цай, хоол, бичиг хэргийн зардлыг санхүүжүүлсэнд албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн авлага огцом өсөхөд нөлөөлсөн хүчин зүйлийн судалгаа хийгээгүй, гүйцэтгэх удирдлагуудтай байгуулсан контрактыг дүгнэхдээ хэлэлцэж, хариуцлага тооцдог эсэх нь тодорхойгүйгээс авлага нэмэгдэж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.12-т “эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох” гэж заасантай нийцэхгүй бөгөөд аудитын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах контракт гэрээнд авлага, өр төлбөргүй ажиллах, үүсгэхгүй байх, бууруулах ажил зохион байгуулах талаар тусгаж, хариуцлага тооцож байх

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн өмчийн бүртгэлд 39 байгууллагад 282 автомашин бүртгэлтэй бөгөөд үлдэх өртөггүй 26 автомашиныг дуудлага худалдаа зарласан байна. Тайлант оны эцэст үлдэх өртөггүй 114 авто тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа бөгөөд дахин үнэлэх шаардлага үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах";

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, аудитын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашиныг дахин үнэлж, хэрэгцээ шаардлага хангахгүй автомашиныг худалдан борлуулж, шаардлагагүй хөрөнгө бэлтгэхгүй байх

3. Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн өр төлбөр жил бүр өссөн талаар хүчин зүйлийн судалгаа хийдэггүй, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас нийлүүлсэн усны тооцоо, алдагдлыг бууруулах талаар үр нөлөөтэй ажил зохион байгуулаагүй байна.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Эрдэнэт Ус ДТС ОНӨХК нь жил бүр "Цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээ"-г байгуулж, сар бүр тооцоо нийлсэн акт үйлддэг боловч гэрээ дүгнэсэн акт, тэмдэглэл үйлдээгүй байна. Төрийн аудитын байгууллага 2018 онд Эрдэнэт үйлдвэрээс хотын хэрэглэгчдэд нийлүүлж буй усны өртөг, түүнтэй холбоотой үйл ажиллагааны зардалд хийсэн гүйцэтгэлийн аудитаар "Цэвэр, бохир усны алдагдлыг бууруулахад орчин үеийн шинэлэг технологи нэвтрүүлэх шаардлагатай болсон байна" гэж дүгнэн, аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах ажлууд хийгдсэн боловч үр нөлөө үзүүлээгүй байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.2.12-т "эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох" гэж заасантай нийцэхгүй бөгөөд аудитын "иж бүрэн байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас нийлүүлж буй усны алдагдал бодитой эсэхийг тогтоох болон дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд анхаарч, төсвийн хөрөнгийн үр нөлөөг сайжруулах

4. Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-ийн хойшлогдсон өр төлбөр дансны бүртгэл холбогдох хууль, журам, стандартын дагуу бүртгэж буй эсэхийг хянадаггүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.", 14.2.12-т "эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох" гэж заасантай нийцэхгүй бөгөөд аудитын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн сургалт арга зүйгээр ханган, бүртгэл тайлагналыг хянаж, холбогдох шийдвэрийг гаргах

5. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагч нь тайлант онд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 155 мэдээллээс 141 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 14 мэдээллийн хугацааг хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.1-д "төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх"; Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ"; 7 дугаар зүйлийн 7.1-т "шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ", 7.1.3-т "тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж, хугацаа хоцроохгүй мэдээлж байх

6. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эрдэнэт сангийн авлагыг Орхон аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дансанд төвлөрүүлснийг Орхон аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын өр төлбөрт суутган шилжүүлж, одоог болтол гэм буруутай этгээдээр төлүүлээгүйгээс авлагын данс үлдэгдэлтэй байгаа болон иргэнээс авах авлагыг барагдуулаагүй, иргэн төлөх график гаргасан боловч төлөхгүй байгаад хяналт хэрэгжүүлээгүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, аудитын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуулийн байгууллагад шилжүүлсэн авлагыг барагдуулах ажил зохион байгуулж, холбогдох хэлтсийг үр дүнтэй ажиллуулж, хариуцлагыг сайжруулах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орхон аймгийн Засаг дарга	5	7.5	5	7.5			5	7.5				
Аймгийн ИТХурал	1	17.8			1	17.8	1	17.8				
Нийцэл ӨЭМТөв	2	0.9			2	0.9	2	0.9			1	
Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ	4	35.9	1	0.2	3	35.7	4	35.9				
ХББЗА ОНӨААТҮГ	1	0.6			1	0.6	1	0.6				
Эрдэнэт Ус ДТС ОНӨХК	1	10.2	1	10.2			1	10.2				
Их шүтээн цогцолбор ОНӨААТҮГ	2	14.51	1	14.5	1	0.01	2	14.51				
Дүн	16	87.41	8	32.4	5	55.01	6	87.41			1	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орхон аймгийн Засаг дарга	5	607.8					5	607.8				
Жаргалант сумын Засаг дарга	3	19.8					3	19.8				
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	5	29.7			2	29.7	3					
Аймгийн Засаг даргын тамгын газар	4	368.4			1	355.2	3	13.2				
Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	5	11.8	2	1.3	1	0.1	2	10.4				
Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар	6	3.1	2	2.7			4	0.4				
Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	4	35.4	1	0.3	2	35.1	1					
Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар	5	4.2	2	2.2	1	0.0	2	2.0				
Санхүүгийн хяналт, аудитын алба	3	0.3	2	0.3			1					
Мэдээлэл, шуурхай удирдлагын төв	2	0.4	1	0.4			1					
Цэцэрлэгжүүлэлт , ногоон байгууламжийн газар	5	2.0	2	1.9	1	0.1	2					
Байгаль орчин, аялал жуулчлалын газар	4	66.1	1	0.2	1	5.8	2	60.1				
Аймгийн Засаг даргын хуваарилагдаагүй бусад, төсөл хөтөлбөрийн зардал	4	196.1	2	13.2	1	182.9	1					
Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	2	10.6	1	0.6	1	10.0						
Баян-Өндөр сумын Орон нутгийн хөгжлийн сан	3	182.0	2	0.5			1	181.5				
Жаргалант сумын Орон	2	96.4					2	96.4				

нутгийн хөгжлийн сан													
Эрдэнэт сан	1	22.5					1	22.5					
Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан	3	45.2					3	45.2					
Жаргалант сумын Хоршоо хөгжүүлэх сан	2	24.3	1	15.7			1	8.6					
Хотын захирагчийн алба	7	8.2	3	1.4	1	5.6	3	1.2					
Хот тохижуулах газар	9	1,216.9	3	11.2	2	1,014.0	4	191.7					
Орон нутгийн өмчийн газар	2						2						
Нийтлэг үйлчилгээний алба	2	6.1					2	6.1					
Сум дундын ойн анги	3	6.1			1	0.1	2	6.0					
Энхжин мандирваа өрхийн эрүүл мэндийн төв	3	5.27	1	0.07			2	5.2					
Үйлс бадрах өрхийн эрүүл мэндийн төв	3	29.7	1	0.9			2	28.8					
Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв	4	4.3	1	0.2	1	2.0	2	2.1					
Мөнхийн гэгээ өрхийн эрүүл мэндийн төв	5	33.2	1	0.3	1	3.5	2	29.4					
Учралт баяр өрхийн эрүүл мэндийн төв	11	42.8	5	8.2			6	34.6					
Мөнх сүндрэл өрхийн эрүүл мэндийн төв	2	13.2	1	0.5	1	6.7	1	6.5					
Анхны оч өрхийн эрүүл мэндийн төв	3	5.3	1	0.1			2	5.2					
Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төв	3	1.3	2	0.2			1	1.1					
Их шүтээн цогцолбор ОНӨААТҮГ	7	70.79	1	0.09	3	65.1	3	5.6					
Гэр бүлийн ордон ОНӨААТҮГ	3	38.7					3	38.7					
Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ	4	44.4			2	30.0	2	14.4					
Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ	5	2.4	2	2.2	1		2	0.2					
Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа ОНӨААТҮГ	3	15.45	2	1.45			1	14.0					
Эрдэнэт Ус ДТС ОНӨХК	13	351.5	1	2.4	5	308.9	7	40.2					

Жаргалант ус дулаан түгээс станц ОНӨХК	2					2				
Дүн	162	3,618.7	43	68.01	29	2,051.8	90	1,496.9		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Орхон аймгийн Засаг дарга	1							1	
"Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ	1							1	
Аймгийн ЗДТГазар	1					1			
Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ	1							1	
Дүн	4					1		3	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв	1	6.2				1	6.2		
Эрдэнэт УС ДТС ОНӨХК	3	12.05	1	0.05		2	12.0		
Орон нутгийн хөгжлийн сан	1	0.9				1	0.9		
Орхон аймгийн ЗДТГ	1	7.6				1	7.6		
Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ	1	6.5	1	6.5					
Мөнхсүндрэл өрхийн эрүүл мэндийн төв	1	0.5	1	0.5					
Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч	2	2,498.0				1	2,498.0	1	
Дүн	10	2,531.75	3	7.05		6	2,524.7	1	-
Нийт дүн	14	2,531.75	3	7.05		7	2,524.7	4	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	33	16	17		12	4		
2	ОНӨ	7	6	1		5		1	
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ	1	1			1			
	НИЙТ	42	24	18		19	4	1	